



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянбулаг Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/11/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго:	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН Д.ЦЭНД-АЮУШ ТАНАА 7

2020.02.27 № 181

танай _____ -ны № _____ -т

Г _____ 7

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020131

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн.

-Тайлант онд Сум сурталчлах арга хэмжээг Аж ахуй нэгж байгууллагаар гүйцэтгүүлэхээр Засаг даргын Тамгын газрын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ худалдан авах зардлаас 10000,0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, зарцуулалт тодорхойгүй, хэрэгжилтийг тооцоогүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд зөрчсөн байна

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ



D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Цэнд-Аюуш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.23-аас 2020.02.27-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.25-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2019.12.20-ний өдрийн 133 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго:

Төв Азийн өндөрлөг Баянбулаг хайрхандаа шүтэж, онгон байгалиа хадгалан, оюуны чадамж бүхий ахмад үеэсээ суралцан, хүний хөгжлийг хангаж уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлсэн дэд бүтцэд тулгуурлан, зах зээлд өрсөлдөхүйц нутгийн шилдэг бүтээгдэхүүнтэй хангайн бүсийн тэргүүлэх сум болно.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн чиг үүргийг иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, сэтгэл ханамжтай хүргэхэд оршино гэж үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна..

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 36 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин-г “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 446881,3 мянган төгрөгөөс тооцон 8937,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин-г үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгийн 2% буюу 8937,6 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48450,5 мянган төгрөгөөр буюу 9,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,079.00	-	(3,079.00)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	18,899.40	37,368.40	18,469.00
Үндсэн хөрөнгө	964,899.40	1,013,439.90	48,540.50
Хуримтлагдсан элэгдэл	(388,357.10)	(412,529.40)	(24,172.30)
Нийт хөрөнгө	598,520.70	638,278.90	39,758.20
Өр төлбөр	-	332.20	332.20
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	598,520.70	637,946.70	39,426.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	598,520.70	638,278.90	39,758.20

Авлага дансны үлдэгдэлд өмнөх оноос 3079,0 мянган төгрөгөөр буурч тайлант онд авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18469,0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх болон тайлант оны өвс тэжээлийн тооцоог хийж зарцуулалтыг гаргаагүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 48540,5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 56870,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 48000,0 мянган төгрөгийн автомашин, 2000,0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данснаас аймгийн ИТХТ-ын 2019.12.25 ний өдрийн 129 дүгээр тогтоолоор 5421,6 мянга, сум ИТХТ-ын 2019.05.14 ний өдрийн 12 тогтоолоор 35487,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан. Мөн аймгийн ИТХТ-н

2017.04.18 ний өдрийн "Хөрөнгө худалдан борлуулах тухай" 60 дугаар тогтоолоор 2009 онд ашиглалтад орсон 17420,0 мянган төгрөгийн үнэтэй 00-12 БНХ, УАЗ-469 автомашиныг худалдан борлуулах шийдвэр гарч зарагдсан байхад бүртгэлээс хасаагүй 2019 онд хассан байна.

Биет бус хөрөнгийн данс өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 332,2 мянган төгрөгөөр өссөн нь нягтлан бодогч албан хаагчдаас суутгасан төлбөрийг шилжүүлээгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 638278,9 мянган төгрөг болж 39758,1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардал байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй дахин үнэлгээний дансанд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 600,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 630,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Түрээсийн орлого	600,0	630,0	-30,0	105
Нийт дүн	600,0	630,0	-30,0	105

Өөрийн орлого 30,0 мянган төгрөгөөр өссөн нь тус суманд сургуулийн барилга барьж байгаа ААНБ-аад ус зөөвөрлөж өгсний төлбөрийн орлого байна

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 7 зориулалтад 410282,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 370372,3 мянган төгрөгийг урсгал зардалд 39910,0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 288114,8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 113947,4 мянган төгрөгийг өмнөх оны төсвийн хэмнэлтээс, 600,0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 402662,2 мянган төгрөг буюу 98,1 хувьтай байгаа нь зарцуулаагүй үлдэгдэл 7620,0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсөв захирагчаас буюу аймгийн ЗДТГ-аас шагналын зардал 5,0 мянга, Хүнс хөдөө аж ахуйн газраас оготно устгалын зардал 17280,0 мянга, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын зардал 1500,0 мянга, Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцааны мөнгө 350,0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 1089,0 өмнөх оны нэмэлт

санхүүжилтийн үлдэгдлээс 3470,3 мянга, СХС-ийн төлөлтийн данс андуурч хийгдсэн гүйлгээг залруулаагүй 2592,0 мянга нийт 43004,8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Үүнээс зарцуулаагүй үлдэгдэл, данс андуурсан гүйлгээний 11308,8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 34 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 58630,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4830,0 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 19900,0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 33900,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 58630,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 24730,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл

Тайлант хугацаанд Зочид төлөөлөгчийн зардалд 6000,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 5611,1 мянган төгрөгийн зарцуулж Үүнээс тэмцээн уралдааны шагналд 1023,0 цагаан сарын золголтын арга хэмжээнд 800,0 мянга, мөн томилолтын зардлаас 79,4 мянган төгрөгөөр хүнсний бүтээгдэхүүн худалдаж авч нийт 1902,4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Нэмэлт санхүүжилтийн данснаас оготно устгалын зардлын 694,3 мянга, шагналын зардлыг 40,0 мянган төгрөгөөр илүү зарцуулж төсөв хэтрүүлж зарцуулсан.

Мөн ГБХЗХГ-аас 2018 онд хүүхэд хамгааллын зардалд олгосон 1000.0 мянга, 2019 онд олгосон 1500.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 2018 онд 54.3 мянга, 2019 онд 715.9 мянган төгрөгийг зарцуулж зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн ба 2018 оны буцаан төвлөрүүлсэн мөнгийг олгосон байхад мөн л 2019 онд зарцуулаагүй буцаан төвлөрүүлснээс харахад дээрх мөнгийг аймгийн ОН-ын төсөвт буцаан төвлөрүүлэх.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтууд.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох.

2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын хийгдэж байгаа Сумын ЗДТГ-ын барилгын зураг төсвийн хяналтын зардалд 1000.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас "Бумбат буурь" ХХК-д шилжүүлж журмыг зөрчиж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн 318 дугаар

тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох.

3.Цалингийн зардал

Өмнөх оны цалингийн урьдчилгааны актын төлбөр 248,7 мянган төгрөгийг цалингийн сангаас шилжүүлж, тухайн албан хаагчаас суутган тооцоогүй зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох.

2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Тус байгууллагын авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй мал эмнэлгийн зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгслээс 2011 онд "2011 онд хөрөнгийн бүртгэлд 19,9 сая төгрөгөөр бүртгэж авсан УАЗ-390942 маркийн фургон автомашин нь сумын МЭҮТ-ын дарга Б.Энхболдын нэр дээр бүртгэлтэй холбогдох бичиг баримтыг шилжүүлж аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараах үүрэг хүлээнэ”,19.3.1 техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах; 19.3.2-т “авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн бичиг баримтын бүрдлийг хангах” гэсэн заалтыг тус тус зөрчиж “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөх.

3. Санхүүгийн тайлан дүгнэлттэй холбоотой

Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт Тайлант онд Сум сурталчлах арга хэмжээг Аж ахуй нэгж байгууллагаар гүйцэтгүүлэхээр Засаг даргын Тамгын газрын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ худалдан авах зардлаас 10000,0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, зарцуулалт тодорхойгүй, хэрэгжилтийг тооцоогүй зөрчил илэрсэн, аудитаар илэрсэн алдааны дүн урьдчилж тогтоосон материаллаг байдлын дүнгээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг сумын Засаг дарга Р.Жамъяндорж хүргүүлэв.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 33900,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, кассаар болон нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулж буй орлого, зарлага,

үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулах цаг хугацааны боломжгүйгээс үзээгүй болно.

2.13 Шилэн дансны мэдээлэл:

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг тус тус 7 сард, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 1-9 сард тус тус Бүтэн жилээр тайлагнах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож мэдээлсэн. Энэ нь мэдээллийг зөрүүтэй байршуулсныг залруулж мэдээлснээс үүссэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	10	1	
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	32	4	
5	Тухай бүр	8	96	78	18	
6	Нийт	27	151	125	24	

2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдын цалингийн урьдчилгаатай холбоотой, 3070,0 мянган төгрөгийн төлбөрийн акт гарсны тайлант хугацаанд бүрэн барагдуулсан байна.

2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсөв гүйцэтгэлтэй холбоотой

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд сумын ИТХ-аас сум сурталчлах өдөрлөг зохион байгуулах зардалд зориулан 10.0 сая төгрөгийн төсөв баталсан боловч тухайн зардлыг тушаал шийдвэр гаргалгүй 2019.07.19 ний өдөр "Мягмар наран хишиг" ХХК-ний дансанд шилжүүлсэн байтал 2019.07 сарын 22 ний өдөр ажил гүйцэтгүүлэх гэрээ ЗДТГ-ын дарга байгуулсан нь ажил гүйлгээ гарсны дараа нөхөж гэрээ байгуулсан.

Мөн Нэгдсэн эмнэлгийн "Магсар"-ын хөшөөний засварын зардалд батлагдсан 5000.0 сая төгрөгийг Баянхонгор сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилт дансанд 2019.07.22 өдөр төсөв захирагч гэрээ байгуулаагүй, Баянхонгор сумын Засаг дарга Ж.Мөнхсоёл, иргэн Ч.Энхбат 2 хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, нэхэмжлэхийг хавсаргаж шилжүүлж, зардлаар тайлагнаж бусад төсөв захирагчийн байгуулсан гэрээг санхүүжүүлсэн байна.

Зочид төлөөлөгч хүлээж авахад зарцуулахаар батлагдсан 5611,1 мянган төгрөгийг "Сангийн сайдын" 55 дугаар тушаалаар Гадаад зочид төлөөлөгч, МУ-ыг болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбоотой гарах зочид буудал, хоол,унаа, бэлэг дурсгалын эд зүйлс олгоход зарцуулна. гэж заасан байхад хоол хүнс, буудлын хөлс, цагаан сарын золголтод, тэмцээн уралдаанд зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.

Мөн сумын Засаг даргын гадаа албан томилолтын зардалд 500.0 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардлаас олгосон атлаа санхүүгийн үр дүнгийн тайланд гадаад арга хэмжээнд зарцуулснаар тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны

баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, гэсэн заалтууд зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Хууль, журам хэрэгжихгүй байх, зардалд бүртгэлээр тавих хяналт сулрах, үргүй зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Данс бүртгэлд хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын холбогдох журмуудыг мөрдөж ажиллаж цаашид төсвийн хөрөнгийг ангилал, зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

